

Талх Чихэр ХК (MSE:TCK)

Хөрөнгө Оруулалтын Хураангуй

“Талх Чихэр” ХК нь 1984 онд “Талх Чихрийн комбинат” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, 1999 онд 100% хувьчлагдаж, 3000 гаруй хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа **Монголын топ 100** аж ахуйн нэгжийн нэг юм. Хувьцааны үнэлгээг хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар тооцож үзэхэд бодит ханш **43,687.36 төгрөг байгаа нь 2022.04.15-ны зах зээлийн ханш болох 32,900 төгрөгөөс 32 хувиар илүү буюу тус хувьцааг одоо хямд байна гэдгийг илэрхийлж байна.**

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


(сая төгрөг)	2021	2020	Өөрчлөлт
Нийт хөрөнгө	76,491	73,030	5%
Нийт өр төлбөр	18,816	20,495	-8%
Борлуулалтын орлого	75,804	63,054	20%
Цэвэр ашиг	5,140	3,035	69%

Салбарын шинжилгээ

Гурил, гурилан бүтээгдэхүүн нь хүн амын өргөн хэрэглээний бүтээгдэхүүний нэг бөгөөд хүнсний бүтээгдэхүүний хоногт эзлэх хэмжээг тодорхойлсон судалгааны дүнгээр хоногийн хэрэглээний **63 хувийг үр тариа, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болох гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж байна.**


Сүүлийн жилүүдэд дэлхийн чиг хандлагатай уялдан зохицуулах үйлчлэлтэй гурилан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байна.

График 4. Монгол Улсын гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл




Санал	АВАХ
Бодит ханш	43,687
Өсөлт	32%
Хаалтын ханш (2022.4.15)	32,900
33 үнэлгээ	33.6 тэрбум төгрөг
52 wk ханш	13,240 – 35,000

График 1. Хувьцааны ханш



Эх сурвалж: МХБ

График 2. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




Эх сурвалж: Компанийн мэдээлэл

Ногдол ашгийн түүх

Он	DPS	DP
2020	225	7.5%
2021	250	5%

Эх сурвалж: МХБ

График 3. Хүнсний бүлгийн хоногт эзлэх хэмжээ /2020 он/




Эх сурвалж: УСХ

Санхүүгийн шинжилгээ


Талх Чихэр ХК-ийн Үнэ ашгийн харьцаа (PE ratio) 2020 онд 5.6 байсан бол 2021 онд 5.5 байгаа нь хувьцааны ханш болон нэгж ашгийн харьцаа зэрэг өссөнтэй холбоотой байна. Цэвэр ашиг 2020 онд 3 тэрбум төгрөгөөс 2021 онд 5.1 тэрбум төгрөг болж өссөн нь цэвэр ашгийн маржиныг 5 хувиас 7 хувь болж өсөхөд нөлөөлжээ.

График 5. Үнэ ашгийн харьцаа




2021 онд компанийн нийт хөрөнгө 76.5 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 18.8 тэрбум төгрөг байгаа нь өр төлбөр ба нийт хөрөнгийн харьцаа 0.28-аас 0.25 болон буурахад нөлөөлжээ.

График 6. Өр төлбөрийн харьцаа




Хувьцааны үнэлгээ

Ирээдүйн мөнгөн урсгал



Тус компани 2018 оны эцсийн байдлаар гурилан бүтээгдэхүүний зах зээлд **36 нэр төрлийн бүтээгдэхүүн** үйлдвэрлэн нийлүүлж байсан бөгөөд 2021 оны байдлаар гурилан бүтээгдэхүүний **95 нэр төрлийн бүтээгдэхүүн** үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байгаа нь тус компанийн бүтээгдэхүүний сонголт, зах зээлд эзлэх байр суурь хэр хэмжээгээр өргөжин тэлж жилээс жилд мөнгөн урсгалын хэмжээ нэмэгдэж 2026 он гэхэд 6 тэрбум төгрөгийн мөнгөн урсгалтай болох төлөвтэй байна




2020-2021 хооронд Нарийн боовны хэрэглээ **19%**, талхны хэрэглээ 10% өссөн ба Талх чихэр ХК нь талхны зах зээлийн **70%-ийг** дангаараа эзэлдэг. Санхүүгийн үзүүлэлт сайжирч байгаа болон хувьцааны үнэлгээ зах зээлийн ханшнаас өндөр гарсан зэргийг үндэслэн **АВАХ** зөвлөмжийг санал болгож байна.

Ашигт ажиллагааны харьцаа	2018	2019	2020	2021	2022F	2023F	2024F	2025F	2026F
EPS	1,930	2,399	2,966	5,021	4,417	5,407	6,604	8,049	9,011
Нийт ашгийн маржин	24%	25%	24%	25%	25%	25%	25%	25%	25%
Цэвэр ашгийн маржин	4%	4%	5%	7%	5%	5%	5%	6%	5%
ROE	0.04	0.05	0.06	0.09	0.07	0.08	0.09	0.10	0.10

Өрсөлдөгчийн судалгаа

Талх Чихэр ХК-ийн Борлуулалтын орлого 2020 онд 63 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 76 тэрбум төгрөг болж 20%-иар нэмэгдсэн нь бүтээгдэхүүний чанар болон нэр төрөл нэмэгдсэнтэй нягт холбоотой гэж харж байгаа бөгөөд үүнийгээ ч дагаад цэвэр ашиг даруй 2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь бодитой өсөлт гэдгийг баталж байгаа юм. Харин ижил зах зээлд үйлчилгээ, үйлдвэрлэл явуулдаг Атар-Өргөө ХК-ийн хувьд Борлуулалтын орлого 9.1 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оноос 3% буурсан үзүүлэлт бөгөөд Талх Чихэр ХК-иас даруй 8.5 дахин бага үзүүлэлттэй гарсан. Атар-Өргөө ХК-ийн үнэ ашгийн харьцааг авч үзвэл 72.7 буюу зах зээлийн дунджаас 5 дахин их байгаа нь тухайн хувьцаа нь өндрөөр үнэлэгдсэнийг илтгэж байна.

График 7. Борлуулалтын Орлого & Цэвэр Ашиг



Дүгнэлт

Талх Чихэр ХК-ийн Борлуулалтын орлого жилээс жилд тогтвортой өсөж байгаа бөгөөд энэ нь тухайн компанийн үйлдвэрлэл буй бүтээгдэхүүний тоо, хэмжээ, амт чанар сайжирч АНУ, БНЧУ, БНСУ, Итали, Чех, Франц, Герман, Голланд, Испани, Финланд гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа анх удаа нэвтрүүлэн, үйл ажиллагаагаа улам өргөжүүлснээр хэрэглэгчдийн өдөр тутмын гурилан бүтээгдэхүүний хангаснаар салбартаа тэргүүлж байна.

САНАМЖ:

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөлтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

Холбоо барих

Ард Секюритиз ҮЦК Утас: 11-321899, 96025445

И-мэйл: info@ardsecurities.comВэб хаяг: <http://www.ardsecurities.com>"Ард Холдингс"-ын байр 2 дугаар давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Бэлтгэсэн: У.Сүхдарь

*Гадаад Арилжаа, Хөрөнгө
оруулалтын зөвлөх*

Та гадаад арилжаанд оролцохыг
хүсвэл доорх утсаар холбогдоно уу

Утас: 88448872

И-мэйл: suhdari.u@ardsecurities.com



2022 он

Ард Секюритиз ҮЦК бэлтгэв